



МОНГОЛ УЛСЫН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН
ТУШААЛ

2018 оны 04 сарын 22 өдөр

Дугаар А-132

Улаанбаатар хот

Стратеги төлөвлөгөө, бүтэц, орон
тоо батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэг, 54 дүгээр зүйлийн 54.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.12 дахь заалт, Малын генетик нөөцийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 36 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 188 дугаар тогтоолын 7 дахь заалтын хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Малын үндэсний генийн санг хамгаалах, сайжруулах чиг үүрэг бүхий "Малын удмын сангийн үндэсний төв" Улсын төсөвт үйлдвэрийн газрын стратеги төлөвлөгөөг 1 дүгээр хавсралтаар, бүтцийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Малын удмын сангийн үндэсний төвийн орон тооны дээд хязгаарыг 34 байхаар тогтоож, шаардлагатай гэрээт ажлыг батлагдсан төсвийн хүрээнд бусдаар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

3. Батлагдсан стратеги төлөвлөгөө, бүтэц, орон тооны хязгаар, төсөвт багтаан байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулж, холбогдох хууль тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг Малын удмын сангийн үндэсний төвийн захирал /П.Ганхуяг/-д үүрэг болгосугай.

4. Малын удмын сангийн үндэсний төвийн стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбогдсон зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Т.Жамбалцэрэн/-д даалгасугай.

5. Малын удмын сангийн үндэсний төвийн бүтэц зохион байгуулалт, стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Мал аж ахуйн хөгжлийн бодлого, зохицуулалтын газар /Д.Батмөнх/-т даалгасугай.

6. Энэ тушаал гарсантай холбогдуулан "Малын удмын сангийн үндэсний төвийн үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр батлах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай" Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2016 оны А-66 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсогуй.

САЙД

Ч.УЛААН

00000390

Хүнс, хөдөө аж ахуй,
хөнгөн үйлдвэрийн Сайдын
2020 оны 14 дүгээр сарын 14-ны
өдрийн 17.132 дугаар тушаалын
1 дүгээр хавсралт

МАЛЫН УДМЫН САНГИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ,

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮТЭЦ

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол улсын эдийн засгийн тулгуур болсон мал аж ахуйн салбарыг байгаль, цаг уурын өөрчлөлт, дэлхийн хөгжил, техник, технологийн дэвшил, улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн өрсөлдөх чадвартай, үр ашигтай байх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор мал сүргийн генетик нөөцийг хамгаалах, хадгалах, баяжуулах, ашиглах замаар нэгжийн ашиг шимийг нэмэгдүүлэн чанарыг сайжруулах арга хэмжээг тодорхой бодлого, стратеги төлөвлөгөөний дагуу үндэсний хэмжээнд нэгтгэн зохион байгуулж малын үндэсний генийн санг хамгаалах, сайжруулах үндсэн чиг үүрэг бүхий хэрэгжүүлэх нь Малын удмын сангийн үндэсний төвийн үндсэн үүрэг мөн.

Энэхүү үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор Малын удмын сангийн үндэсний төв улсын төсөвт үйлдвэрийн газрын (цаашид "Малын удмын сангийн үндэсний төв" гэх)-ийн үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөг холбогдох журамд нийцүүлэн боловсруулав. Хөтөлбөрийг засаглал болон өөрчлөлтийн удирдлага, байгууллагын өөрчлөлтийн онол, арга зүй, олон улсын туршлага, өмнөх хөтөлбөрүүдийн туршлага, сургамжид үндэслэн оролцооны аргыг ашиглан боловсрууллаа. Мөн салбарын өмнө тулгамдаж байгаа асуудал, тэргүүлэх чиглэл, стратегийн зорилт, үйл ажиллагааны гол зорилт, байгууллагын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн үндсэн үүрэг, чиг үүргийг тодорхойлоход хэрэглэдэг арга зүйг ашиглав.

Хөтөлбөрийг боловсруулахдаа Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны холбогдох газар, хэлтэс, мэргэжлийн хүмүүсийн саналыг авч тусган боловсруулав.

1.1. Хөтөлбөр боловсруулах үндэслэл:

Хөтөлбөрийг Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хууль, Улсын Их Хурлын 1996 оны 38 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах бодлого"-ын баримт бичиг, Засгийн газрын 2019 оны 213 дугаар тогтоолоор баталсан "Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр", Засгийн газрын 2019 оны 36 дугаар тогтоолоор баталсан "Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам"-ыг тус тус үндэслэн боловсруулав.

2.1. Малын удмын сангийн үндэсний төвийн үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөг дараах хууль, тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ. Үүнд:

- "Малын генетик нөөцийн тухай" хууль /8.1.4, 8.1.9, 8.5, 9.11, 10.5, 12.2, 12.4, 15.1-15.4, 16.2, 16.5, 18.2.1-18.2.3, 18.2.5-18.2.6 дахь заалт/;
- "Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай" хууль /10.1.1 дэх заалт/;
- "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" хууль /15.11.7 дэх заалт/;

2.2. Түүнчлэн тус байгууллага нь үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхдээ Монгол Улсын Их Хурал, Засгийн Газраас батлан хэрэгжүүлж байгаа дор дурдсан бодлого, үндэсний хөтөлбөр, журам, стандартыг мөрдлөг болгон ажиллана. Үүнд:

- Улсын их хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан "Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал" /3.4.2.1, 3.4.2.2, 3.4.2.6, 3.4.2.9, 3.5.3.5 дахь зорилт /;
- Улсын их хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030" хөгжлийн бодлогын баримт бичиг;
- Улсын их хурлын 2015 оны 104 дүгээр тогтоолоор баталсан "Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого" /2.1.1, 2.1.3, 2.1.5 дахь зорилт/;
- Улсын их хурлын 2010 оны 23 дугаар тогтоолоор баталсан "Монгол мал" үндэсний хөтөлбөр /2 дугаар тэргүүлэх чиглэлийн хүрээний зорилт, үйл ажиллагаа/;
- Засгийн газрын 2018 оны 400 дугаар тогтоолоор баталсан "Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих" үндэсний хөтөлбөр /3.3, 3.4, 3.3.1, 3.3.2, 4.4.5, 4.4.8, 4.4.12 дахь заалт/;
- Засгийн газрын 2020 оны 34 дүгээр тогтоолоор баталсан "Монгол малчин" үндэсний хөтөлбөр /4.2.3, 4.3.1, 4.3.6 дахь заалт/;
- "Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2018 оны 188 дугаар тогтоолын 7 дахь заалт;
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2018 оны А-187 тушаалаар баталсан "Малын удмын сангийн үндэсний төвийн дүрэм";
- "Малын үндэсний генийн санд үржүүлгийн бүтээгдэхүүн байршуулах, бүртгэх, зарцуулах, хяналт тавих журам";
- "Малын удмын сангийн үндэсний төвийн үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага", /Монгол улсын стандарт 5817:2007/;
- "Цөм сүргийн үржлийн төвийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага /Монгол улсын стандарт MNS 5818:2007/;
- Малын үр үйлдвэрлэлд тавигдах ерөнхий шаардлага MNS 4089:2019;
- Бусад хууль, тогтоомж, бодлогын баримт бичиг, үндэсний хөтөлбөр

2.3. Малын удмын сангийн үндэсний төвийн мандат буюу хуулиар олгосон эрх хэмжээг Малын генетик нөөцийн тухай хуулиар нарийвчлан зохицуулсан. Малын генетик нөөцийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт "Малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяа малын үндэсний генийн санг хамгаалах, сайжруулах чиг үүрэг бүхий төрийн үйлчилгээний байгууллага байна." гэж заасан.

Түүнчлэн тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.6 дахь хэсэг, 6 дугаар зүйлийн 6.2, 6.5 дахь хэсэг, 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 15.3 дахь хэсэгт тус байгууллагын хариуцах чиг үүргийг тодорхойлон заасан. Үүнд:

2.3.1. Монгол малын генийг доройтох, мөхөх, устахаас сэргийлж хамгаалах зорилгоор үржүүлгийн бүтээгдэхүүнийг хадгалах үндэсний генийн санг бүрдүүлэх, баяжуулах;

2.3.2. Малын үндэсний генийн санг дараах байдлаар хамгаалах:

- Малыг үндэсний, бүс нутгийн, эсхүл төрөл зүйлийн төвшинд энэ хуулийн 12.1.1-д заасан орчинд цөм сүрэг бүрдүүлж хамгаалах;
- малыг төрөл, зүйлийн хувьд хувиран өөрчлөгдөх, доройтох, мөхөхөөс сэргийлэн үржүүлгийн бүтээгдэхүүний дээж, сорьц, цуглуулгыг бий болгож, генийн санд хадгалах;
- энэ хуулийн 12.3, 15.3.9-д заасан шилмэл малаас үр, хөврөл үйлдвэрлэх болон гадаадаас өндөр ашиг шимт малын үржүүлгийн бүтээгдэхүүнийг авах замаар генийн санг арвижуулж, үржүүлэгт ашиглах;
- малын үржил, селекцийн шинж тэмдгийн илрэл, үзүүлэлтийг тодорхойлох, харьцуулах, тэдгээрийн хувьсал, өөрчлөлтийг тогтоох, үржлийн үнэт чанарыг үнэлэх, ашиглах.

2.3.3. Үржүүлгийн бүтээгдэхүүний бүртгэлийг хариуцан гүйцэтгэх;

2.3.4. Малын удам зүйн үнэлгээг технологийн арга зүй, аргачлал, зааврын дагуу холбогдох байгууллага, нэгжтэй хамтран эсхүл бие даан хийх;

2.3.5. Малын геномын өвөрмөц тогтцын үзүүлэлтийг тодорхойлох молекул генетикийн шинжилгээг холбогдох байгууллага, нэгжтэй хамтран эсхүл бие дааж хийж, энэ тухай бүртгэл хөтлөх

2.3.6. Дотоодод ашиглах болон гадаадад гаргах үржүүлгийн бүтээгдэхүүнд гарал үүслийн тодорхойлолт олгох;

2.3.7. Гадаадаас авсан үржүүлгийн бүтээгдэхүүнийг генийн санд тусгайлан хадгалж, бүртгэх, гарал үүсэлд нь хяналт тавих, тэдгээрийг энэ хуулийн 11.8-д заасан стратегид нийцүүлэн хуваарилах, ашиглах, үр дүнг тооцох, ашиг шимийн өөрчлөлтийн үнэлгээг хийх;

2.3.8. Үржүүлгийн бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангах, ашиглалтын талаарх холбогдох бүртгэл, мэдээллийг нэгдсэн санд тогтмол оруулж байх;

2.3.9. Малын чанар, үүлдэрлэг байдлыг сайжруулах, үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээнд биотехнологийн ололтыг нэвтрүүлэх, нутагшуулах, дэлгэрүүлэх;

2.3.10. Мал үржүүлгийн техникч, мал ангилагч-шинжээч бэлтгэх, давтан сургах ажлыг зохион байгуулах;

2.3.11. Зохиомол хээлтүүлгийн үйлчилгээний хүрээг тогтоох, өргөтгөх, шаардлагатай багаж, тоног төхөөрөмж, урвалжаар хангах;

2.3.12. Үүлдэр, омгийн мал, түүний үржүүлгийн бүтээгдэхүүнд молекул генетикийн шинжилгээ хийх;

2.3.13. Гойд ашиг шимт цөм сүрэг, цэвэр үүлдрийн донор болон тээгч малыг байршуулж ашиглах.

Гурав. Байгууллагын алсын хараа, эрхэм зорилго

3.1. Малын удмын сангийн үндэсний төвийн алсын хараа нь малын үндэсний генийн санг хамгаалах, сайжруулах, малын үржүүлэг, биотехнологийн ажил, үйлчилгээг зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн хөгжүүлэх, мал аж ахуйн салбарын эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэхэд чиглэгдэнэ.

3.2. Малын удмын сангийн үндэсний төвийн эрхэм зорилго нь Монгол Улсын мал сүргийг уугуул орчинд болон генийн төвшинд хадгалах, хамгаалах, сайжруулах, малын нөхөн үржихүйн биотехнологи, генийн инженерчлэлийн ололтыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, гойд ашиг шимт малаас үржүүлгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, стандартын шаардлага хангасан үржлийн бүтээгдэхүүнээр үйлдвэрлэгчид, хэрэглэгчдийн хангах, мал сүргийн ашиг шимийг нэмэгдүүлэхэд оршино.

Дөрөв. Байгууллагын орчны шинжилгээ:

4.1. Байгууллагын дотоод орчны шинжилгээ

Малын үржүүлэг, биотехнологийн олон арга дотроос ашиг шим арвин, нэг хээлтүүлэгч малын үрийг зохиосон аргаар авч, олон хээлтэгч малд нэг дор суулгаснаар олон төл зэрэг авах зохиомол хээлтүүлгийн арга дэлхийд 1940-өөд оны эхэнд үйлдвэрлэлд нэвтэрчээ. Манай улсад энэ арга 1953 оноос туршилтын журмаар нэвтэрч, улмаар 1958 онд улсын хэмжээнд нэвтрүүлэхээр БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 31 дүгээр тогтоол гарч, уг тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Хөдөө аж ахуйн яамны сайдын 189 дүгээр тушаал гарч, хот орчмын сангийн аж ахуй, нэгдлүүдийн малд зөөвөр үрээр зохиомол хээлтүүлэг явуулах станцыг Улаанбаатар хотод байгуулахаар шийдвэрлэсэн нь өнөөгийн Малын удмын сангийн үндэсний төвийн үйл ажиллагааны эхлэл болсон ба тус байгууллагын хөгжлийг доорх дөрвөн үе шатанд хуваан үздэг байна. Үүнд:

Хөгжлийн нэгдүгээр үе (1958-1980 он): Малын зохиомол хээлтүүлгийн технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх арга хэмжээг өргөтгөх зорилгоор орон нутагт малын үржил-зохиомол хээлтүүлгийн нийт 36 станц байгуулж, хээлтүүлэгч малаас авсан үрийг шингэлэх, 0 градуст хадгалах, зөөвөрлөн хүргэж ашиглах технологийг нэвтрүүлж, энэ аргаар жилд дунджаар 1,3 сая эм хонь, 40,0 гаруй мянган үнээ, 45,0 гаруй мянган эм ямааг зохиомлоор хээлтүүлж байсан. Энэ үед малын зохиомол хээлтүүлгийн аргыг өргөнөөр ашиглан эх орны нарийн ноост "Хангай", нарийвтар ноост "Ерөө", "Орхон" үүлдэр, "Жаргалант үржлийн хэсэг", арьсны чиглэлийн "Сүмбэр", ноосны чиглэлийн "Байдраг" үүлдрийн хонь, ноолуурын чиглэлийн "Говь

гурван сайхан" үүлдрийн ямаа, сүүний чиглэлийн "Хар тарлан", "Семминталь", "Алатау" үүлдрийн үхэр зэрэг арвин ашиг шимт малыг зохион бүтээсэн.

Хөгжлийн хоёрдугаар үе (1980-1994 он): 1980 оноос малын үрийг -196 хэмд хөлдөөн хадгалах, ашиглах технологийг боловсруулан үйлдвэрлэлд нэвтрүүлж, БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1980 оны 256 дугаар тогтоолоор "Хээлтүүлэгч малын үрийн улсын сан"-г байгуулж, 1984 оны БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 156 дугаар тогтоолоор Хүнс, хөдөө аж ахуйн яамны харьяа "Малын зохиомол хээлтүүлгийн төв станц", 1987 онд Хүнс, хөдөө аж ахуйн Сайдын тушаалаар "Мал аж ахуйн үржил, биотехнологийн төв", 1992 онд Хүнс, хөдөө аж ахуйн Сайдын А/08 тушаалаар "Малын удмын сангийн үндэсний төв" нэртэйгээр Хөдөө аж ахуйн яамны харьяанд үйл ажиллагаагаа явуулж ирсэн байна.

Энэ үед гадаадаас арвин ашиг шимт махны, сүүний чиглэлийн 10 орчим бухыг авчирч нутагшуулан, хээлтүүлэгч малын үрийг -196 градуст өнгөлсөн үрлэн хэлбэрээр гүн хөлдөөж хадгалах Харьковын технологийг нэвтрүүлж, үр үйлдвэрлэлийг өргөн цар хүрээнд явуулжээ. Махны, сүүний болон хосолмол ашиг шимийн чиглэлийн хээлтүүлэгчээс 1985-1990 онуудад нийт 1,5 сая тун үр үйлдвэрлэж, 400 үнээнд шилжүүлснээр 36 саалийн механикжсан ферм, махны чиглэлийн үхэр үржүүлдэг 9 сангийн аж ахуй, Архангай, Булган, Дорнод, Хэнтий, Хөвсгөл аймгуудын эрчимтэй эрлийзжүүлгийн бүсийн 38 нэгдэлд үнээг гүн хөлдөөсөн үрээр зохиомлоор хээлтүүлэх шинэ технологийг нэвтрүүлсэн байна. Энэ үед нэг бухнаас 80-150 тугал, нэг хуцнаас 250-350 хурга авч байжээ. Зохиомол хээлтүүлгийн үр дүнд гарсан эрлийз үхэр нь монгол үхэрнээс 5-10 дахин их сүү, махны үхэр 60-70 кг-аар их мах өгдөг сүрэг бий болж, 1990 оны эцсийн байдлаар цэвэр эрлийз үхэр 252.4 мянга, цэвэр эрлийз хонь 1.2 сая, цэвэр эрлийз ямаа 427.9 мянгад хүрч, зохиомол хээлтүүлгийн аргаар жилд 1.9 сая хонь, 40 мянга гаруй үнээг хээлтүүлж байжээ. Түүнчлэн хар тарлан, алатау, симменталь, талын улаан, лиммузин, герфорд бухны бүгд 439.2 мянган тун үртэй болсноос гадна 1995 оноос хойш Орхон, Ерөө, Хангай, Халх, Байдраг, Үзэмчин, Барга үүлдрийн хуцны, Баяндэлгэрийн улаан, Залаа Жинстийн цагаан ухны үрийн зохих нөөц бий болгожээ.

Хөгжлийн гуравдугаар үе (1995-2009 он): Зах зээлийн системд шилжсэнтэй холбоотойгоор тус байгууллагын үйлчилгээний хүрээний саалийн механикжсан фермүүд, цөцгийн тосны аж ахуйнуудад өмч хувьчлал явагдаж, зарим нь бие даан ажиллах чадваргүй болсны улмаас тарж бутарсан тул тус байгууллагын ажиллах орон тоог цомхтгож, үр үйлдвэрлэлийн үйл ажиллагаа зогсож, зөвхөн генийн санг хамгаалах чиглэлийн ажил нь хийгдэж байв. Гэхдээ энэ үед эрдэм шинжилгээний байгууллагын эрдэмтэн, судлаачид үр тогтсон хөврөл үрийг угааж авч, тээгч малд суулгах технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх ажлуудын эхлүүлсэн ба энэ арга нь малын үржлийн үйл ажиллагааг эрчимжүүлж зохиомлоор дотоод шүүрлийн зохицуулалтыг бий болгон донор малаас бэлгийн нэг удаагийн сэрлээр олон өндгөн эс гадагшлуулж үр тогтсон хөврөл үрийг угаан авч тээгч малд шилжүүлэн ашиглах технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлсэн байна. Энэ аргыг Монгол ямаан дээр туршин нэвтрүүлж донор 78 ямаанаас үр тогтсон 379 өндгөн эсгийг угаан авч тээгч ямаанд

шилжүүлэн суулгасан 100 ямаанаас 76 ишиг авч, 32,3 хувь нь ихэрлэж, нэг ямаанаас 5,5 үр төлийг нэг удаа авах боломжтойг харуулсан юм.

Засгийн газрын 1999 оны 53 дугаар тогтоолоор "Цөм сүргийн талаар авах арга хэмжээний тухай", 2006 онд Засгийн газрын 172 дугаар тогтоолоор малын удмын санг хамгаалах, малын үржлийн ажил, үйлчилгээнд биотехнологи, генийн инженерчлэлийн дэвшилтэт аргыг нэвтрүүлэх үүрэг бүхий "Малын удмын сангийн үндэсний төв"-ийг Хүнс, хөдөө аж ахуйн сайдын эрхлэх асуудлын хүрээнд байгуулан ажиллуулах, цөм сүргийн мал өсгөн үржүүлж сайн чанарын хээлтэгч, хээлтүүлэгч бойжуулж бүс нутгийн хэрэгцээг хангах үүрэг бүхий Цөм сүргийн үржлийн төвүүдийг Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Хөдөө аж ахуйн их сургууль, Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эзэмшилд байгаа цөм сүргийн малыг үндсэн болон эргэлтийн хөрөнгийн хамт шилжүүлэх замаар байгуулж ажиллуулахаар тус тус шийдвэрлэсэн байна.

Хөгжлийн дөрөвдүгээр үе (2010 оноос одоог хүртэлх): Монгол Улсын Их Хурлын 2010 оны 23 дугаар тогтоолоор Монгол мал үндэсний хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлж эхэлснээр Малын удмын сангийн үндэсний төвийн тогтолцоог боловсронгуй болгох, шинээр цогцолбор байгуулах ажлын эрх зүй, хөрөнгө оруулалтын асуудлыг дорвитой шийдвэрлэх суурийг тавьж, Дархан-Уул аймгийн Хонгор суманд улсын төсвийн хөрөнгөөр шинэ цогцолбор байгуулах бүтээн байгуулалтын ажлыг 2011-2017 оны хугацаанд хийж, ашиглалтад оруулав.. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2016 оны А-66 дугаар тушаалаар Малын удмын сангийн үндэсний төвийн үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орон тоог баталсны дагуу үйл ажиллагааны хэрэгжилт явагдаж байна.

Засгийн газрын 2013 оны 420 дугаар тогтоолоор 13 аймгийн "Цөм сүргийн үржлийн төв"-ийг Малын удмын сангийн харьяанд шилжүүлэн ажиллуулж, одоо 11 аймгийн Цөм сүргийн төвд есөн үүлдрийн 9,5 мянган хонь, дөрвөн үүлдрийн 2,8 мянган ямаа, хоёр үүлдрийн 87 үхэр, Монгол үүлдрийн 137 адуу, Дөхөм тунгалаг үүлдрийн 103 тэмээ, нийт 12,7 мянган цөм сүргийн малтай байна.

Монгол Улсын Их Хурлын 2017 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн нэгдсэн чуулганаар Малын генетик нөөцийн тухай хуулийг баталж, 2018 оны 06 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлсэн. Малын генетик нөөцийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт "Малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн төрийн төв байгууллагын харьяа малын үндэсний генийн санг хамгаалах, сайжруулах чиг үүрэг бүхий төрийн үйлчилгээний байгууллага байна" гэж, мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэгт хариуцах чиг үүргийг тус тус зааснаар Малын удмын сангийн үндэсний төвийн үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндэс бүрдсэн. Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 188 дугаар тогтоолоор Малын удмын сангийн үндэсний төвийг малын үндэсний генийн санг хамгаалах, сайжруулах чиг үүрэг бүхий улсын төсөвт үйлдвэрийн газар болгон өөрчлөн зохион байгуулах шийдвэр гарсны дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн

үйлдвэрийн сайдын 2018 оны А-187 дугаар тушаалаар тус байгууллагын дүрмийг шинэчлэн баталсан.

5. Байгууллагын стратегийн зорилт:

Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, үндэсний хөтөлбөр, болон сайдын эрхлэх асуудлын хүрээний шийдвэр зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд хэрэглэгч, үйлчлүүлэгчдийг чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээгээр тогтмол, шуурхай хангах, яамны сайд, удирдлагад өндөр мэргэшлийн, цаг үеэ олсон шуурхай зөвлөгөө, мэдээ, мэдээлэл өгч ажиллахад байгууллагын үйл ажиллагааны стратегийн мөн чанар оршино.

Малын удмын сангийн үндэсний төв нь байгууллагын алсын хараа, эрхэм зорилгын хүрээнд дор дурдсан стратегийн зорилгыг хэрэгжүүлнэ. Үүнд:

5.1. Нэгдүгээр зорилт: Малын генетик нөөцийг уугуул болон тусгай орчинд хамгаалах, хадгалах, үндэсний генийн сан, цөм сүрэг бүрдүүлэх, хяналт тавих;

5.2. Хоёрдугаар зорилт: Мал аж ахуйн үйлдвэрлэлд малын нөхөн үржихүйн биотехнологи, шинжлэх ухааны ололт, био техникийн дэвшилтэт аргыг нэвтрүүлэх, үржүүлгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, генийн санг баяжуулах, үр дүнтэй ашиглах, хяналт тавих;

5.3. Гуравдугаар зорилт: Малын зохиомол хээлтүүлгийн ажил, үйлчилгээг үндэсний хэмжээнд зохион байгуулах, малын үүлдэрлэг байдал, ашиг шимийн гарц, чанарыг нэмэгдүүлэх, үржлийн малын удам зүйн дэвшлийг сурталчлах;

5.4. Дөрөвдүгээр зорилт: Малын үржил, селекцийн шинж тэмдгийн илрэл, хувьсал, өөрчлөлтийг тодорхойлох, удам зүйн болон үржлийн үнэт чанарын үнэлгээ, молекул генетикийн шинжилгээ хийх, бүртгэл хөтлөх, судалгаа, шинжилгээг хөгжүүлэх;

5.5. Тавдугаар зорилт: Холбогдох хууль тогтоомж, төрийн бодлого, хөтөлбөр, дүрэм, журам, заавар, стандарт, байгууллагын стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, үйл ажиллагааны үр дүнг сайжруулах;

5.6. Зургадугаар зорилт: Байгууллагын бүтэц, зохион байгуулалтын болон малын үржүүлэг, технологийн чиглэлийн боловсон хүчний нөөцийг бүрдүүлэх, үр чадварыг нэмэгдүүлэх, эрх бүхий сургалтыг зохион байгуулах.

6. Байгууллагын стратегийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

Малын удмын сангийн үндэсний төв нь стратегийн зорилтын хүрээнд дор дурьдсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

6.1. Стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд:

6.1.1. Монгол малын ген доройтох, төрөл, зүйлийн төвшинд хувиран өөрчлөгдөх, тоо толгой цөөрөх, устаж мөхөхөөс сэргийлж, тэдгээрээс үржүүлгийн бүтээгдэхүүний дээж, сорьц авч, үндэсний генийн санд тусгай орчинд хадгалах, хадгалалтын аюулгүй байдлыг хангах,

6.1.2. Монгол малыг үндэсний, бүс нутгийн, төрөл, зүйлийн төвшинд уугуул орчинд нь цөм сүрэг бүрдүүлж хамгаалах, үржүүлэх, үржлийн стратегийн дагуу ашиглах, судалж, сайжруулах;

6.1.3. Баталгаажсан үүлдрийн мал, гадаадаас сайжруулагчаар авчирсан үржлийн малын гарал үүсэлд хяналт тавьж, тэдгээрээс үр, хөврөл үйлдвэрлэж, генийн санд байршуулж ашиглах, бүртгэлээр үр дүнг хянах;

6.1.4. Монгол малын генийг доройтох, устахаас сэргийлэн хамгаалах зорилгоор баталгаажсан үүлдэр, үүлдрийн хэсэг, омог, хэвшлийн малаас үр, хөврөл үйлдвэрлэн үндэсний генийн санд хадгалах;

6.1.5. Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчит цөм сүргийн аж ахуйн бүтэц, зохион байгуулалт, үйлчилгээний хүртээмжийг оновчтой болгож, үр дүнг сайжруулах, бүс нутгийн үйлчилгээ үзүүлэх тогтолцоонд шилжүүлэх;

6.1.6. Хувийн хэвшилд байгаа цөм сүргийн малаас стандартын шаардлага хангасан хээлтэгч, хээлтүүлэгч бойжуулж, зөвшөөрөгдсөн бүс нутагт сайжруулагчаар ашиглан, иргэд, малчид, фермерийн хэрэгцээг хангах ажлыг зохион байгуулах;

6.1.7. Цөм сүргийн малд жил бүр үзлэг, ангилалт хийж, заазлалт, тохируулан сонголтын мэргэжлийн өндөр төвшинд зохион байгуулж, чанарыг сайжруулах;

6.1.8. Цөм сүргийн аж ахуйг чадавхжуулах, үйл ажиллагааг нь бэхжүүлэх чиглэлээр тухайн орон нутаг, судалгаа шинжилгээний байгууллага болон гадаадын төсөл, хөтөлбөртэй хамтран ажиллах.

6.2. Стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд:

6.2.1. Гойд ашиг шимт цөм сүрэг, цэвэр үүлдрийн донор болон тээгч малыг байршуулж, үр, хөврөл, бусад үржүүлгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, бүртгэх, эрүүл ахуй, аюулгүй байдалд хяналт тавих, генийн санг баяжуулах, үр дүнтэй ашиглах;

6.2.2. Малын үржүүлэгт ашиглах гүн хөлдөөсөн үр, хөврөлийг ашиглах хуваарилалтыг үржлийн ажлын стратегид нийцүүлэн хийх, бүртгэл хөтлөх, үржүүлгийн бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхойлох, ашиглалтын үр дүнг тооцох, тайлагнах;

6.2.3. Гадаадаас авсан үржүүлгийн бүтээгдэхүүний гарал үүсэлд хяналт тавих, генийн санд тусгайлан хадгалах, бүртгэх, үржлийн ажлын стратегид нийцүүлж хуваарилах, үр дүнг тооцох, ашиг шимийн өөрчлөлтөд үнэлгээ хийх;

6.2.4. Дотоодын төр, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, иргэд, фермерүүдэд үржүүлж байгаа цэвэр үүлдрийн малаас үр, үржүүлгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж генийн санд хадгалж, баяжилт хийх, ашиглах;

6.2.5. Гадаадаас сайжруулагчаар авсан үржлийн малын гарал үүсэлд хяналт тавьж, тэдгээрээс үр, хөврөл үр авч генийн санд хадгалах, тэдгээрийг бүртгэж мэдээллийн санд оруулан зөвшөөрөгдсөн бүс нутагт сайжруулагчаар ашиглах;

6.2.6. Гойд ашиг шимт, шилмэл малын тоог нэмэгдүүлэх, удам гарваль, ашиг шимийн бүртгэл, мэдээллийг сайжруулах, төрийн захиргааны төв байгууллагын мэдээллийн сантай холбох, харилцан мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх;

6.2.7. Дотоодоо ашиглах болон гадаадад гаргах үржүүлгийн бүтээгдэхүүний гарал үүслийг баталгаажуулж, тодорхойлолт олгох.

6.3. Стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд:

6.3.1. Монгол Улсын малын үржлийн ажлын стратегийн хүрээнд малын үржүүлэг, нөхөн үржихүй биотехнологийн ажил, үйлчилгээний тархалтын хүрээг өргөтгөхөд чиглэгдсэн арга хэмжээг хэрэгжүүлэх;

6.3.2. Зохиомол хээлтүүлгийн үйлчилгээний хүрээг тогтоох, мал сүргийн ашиг шимийн гарц, чанарыг сайжруулах ажлыг зохион байгуулах, өргөтгөх;

6.3.3. Мал үржүүлэгчдийн захиалга, хэрэгцээнд тулгуурлан хөврөл үр шилжүүлэн суулгах арга технологийг хэрэглэн, удам зүйг дэвшлийг түргэн хугацаанд түгээх боломжийг бүрдүүлэх;

6.3.4. Гадаад орон, олон улсын байгууллага, эрдэм шинжилгээ судалгаа, үйлдвэрлэлийн чиглэлийн гарааны компаниудтай хамтран мал үржүүлэг, биотехнологи, генийн инженерчлэлийн чиглэлийн зарим судалгаа хийх, тодорхой цэгц ажлуудыг хамтран гүйцэтгэх;

6.3.5. Орон нутагт зохиомол хээлтүүлгийн салбаруудыг бий болгож, чадавхийг сайжруулан биотехнологийн ажил үйлчилгээг өргөжүүлэх, мал үржүүлэг, нөхөн үржихүйн чиглэлээр гаргасан эрдэм шинжилгээний ажлын үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх;

6.3.6. Зохиомол хээлтүүлгийн техникчдийг мэргэжил, арга зүйгээр хангаж, гэрээгээр ажиллах, шаардлагатай багаж, тоног төхөөрөмж, урвалжаар хангах, хариуцсан бүсэд үйлчилгээг нь өргөтгөх, тэдгээрийн нийгмийн баталгааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх;

6.3.7. Үржүүлгийн бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангах, ашиглалтын бүртгэл, мэдээллийг хөтлөх.

6.4. Стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд:

6.4.1. Малын геномын өвөрмөц тогтцын үзүүлэлтийг тодорхойлох молекул генетикийн шинжилгээ, удам зүйн үнэлгээг технологийн арга зүй, аргачлал, зааврын дагуу холбогдох байгууллага, судлаачидтай хамтран хийх;

6.4.2. Улсын хэмжээнд үржүүлж байгаа арвин ашиг шимт мал, цөм сүргийн малын удам гарваль, ашиг шимийн төлөв байдалд дүн шинжилгээ хийх, мэдээллийн санг бүрдүүлэх, үр дүнг тайлагнах;

6.4.3. Арвин ашиг шимт малын үүлдэр, үржлийн хэсэг, омгийн малын талаар мэдээ, судалгаа гаргах, бусад орон, олон улсын холбогдох байгууллагатай мэдээлэл солилцох;

6.4.4. Монгол улсад албан ёсоор баталгаажсан үүлдэр, омог, хэвшлийн малд удам зүйн үнэлгээг холбогдох байгууллага, судлаачидтай хамтран хийх, арвин ашиг шимт малын мэдээ, мэдээллийг хэрэглэгчдэд түгээж, үржлийн ажил үйлчилгээгээр хангаж ажиллах;

6.4.5. "Сүүний үхрийн гарваль, ашиг шимийн бүртгэл, мэдээллийн сан"-г ашиглан сүүний үхэр үржүүлэгчдэд үзүүлэх үржлийн ажил, үйлчилгээний мэдээллийг цахим хэлбэрт шилжүүлж, үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй болгох;

6.4.6. Нийслэл, аймаг бүс нутгийн хэмжээнд гойд ашиг шимт малын үзэсгэлэн, худалдаа зохион байгуулахад хамтран оролцох.

6.5. Стратегийн 5 дугаар зорилтын хүрээнд:

6.5.1. Хууль, тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг хугацаанд нь тайлагнах, салбарын Сайд, болон холбогдох нэгж, байгууллагыг үнэн зөв мэдээллээр хангаж ажиллана

6.5.2. Холбогдох хууль, тогтоомж, шийдвэрийн төсөл боловсруулахад мэргэжил, арга зүйн санал, зөвлөгөө өгч ажиллана

6.5.3. Малын генетик нөөцийг хамгаалах, сайжруулах чиглэлээр сайд болон аппаратын шийдвэр боловсруулахад мэргэжлийн дэмжлэг, зөвлөгөө үзүүлнэ

6.5.3. Аймаг, нийслэл, сум, дүүргийн төр захиргааны байгууллага, эрдэм шинжилгээний болон мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгж, холбоодтой хамтран ажиллах, мэргэжил, арга зүйн зөвлөмж, зөвлөгөө үзүүлнэ.

6.5.4. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тогтоол шийдвэр, Сайд, удирдлагаас өгсөн үүрэг, чиглэлийн биелэлтийг шуурхай зохион байгуулах ба гүйцэтгэлийн баримт бичиг шаардлага хангаагүй, буруу мэдээ, мэдээлэл гаргасан тохиолдолд хариуцсан мэргэжилтэнд болон албадын дарга нарт холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариуцлага тооцно.

6.5.5. Засгийн газраас хэрэгжүүлж буй хөтөлбөр, төслүүд болон төвийн үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг тухайн асуудал хариуцсан алба дүгнэн тайлагнаж, мэдээллийн үнэн, зөв эсэх, чанарын байдалд хариуцлага хүлээнэ.

6.6. Стратегийн 6 дугаар зорилтын хүрээнд:

6.6.1. Байгууллагын ажилтан, албан хаагчид болон үржлийн ажил үйлчилгээний хувийн хэвшлийн нэгж, байгууллагуудын мэргэжилтнүүдийг мэргэжлийн удирдлагаар хангах;

6.6.2. Байгууллагын үйл ажиллагааг сар, жилээр төлөвлөн, албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж, биелэлтэд дотоод хяналт, шинжилгээ, үнэлгээг тогтмол хийж, хариуцлагыг дээшлүүлж ажиллах;

6.6.3. Байгууллагын үйл ажиллагаанд үр дүнд суурилсан үнэлгээ, тогтолцоог нэвтрүүлэх, байгууллагын эд хөрөнгийн эзэмшил, ашиглалт, нягтлан бодох, бүртгэлийг сайжруулах, холбогдох стандартыг нэвтрүүлэх, мөрдөх,

6.6.4. Төрийн үйлчилгээний соёл, хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангаж ажиллах, сурталчлан таниулах, малын үржил, биотехнологийн чиглэлээр гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх;

6.6.5. Ажилтан албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах, нарийн мэргэшүүлэх сургалтад хамруулах;

6.6.6. Төрийн өмчийн цөм сүргийн аж ахуйн өнөөгийн нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт өгч цаашид чанартай малаар цөм сүрэг бүрдүүлэх, чанаржуулах, үйл ажиллагааны үр дүнг сайжруулж, ашиг орлогыг нэмэгдүүлэхтэй холбогдсон цогц арга хэмээг төлөвлөн холбогдох шатанд танилцуулж шийдвэрлүүлэх,

6.6.7. Орон нутгийн цөм сүргийн аж ахуйдын санхүү, тайлан бүртгэлийн ажлын чанарыг сайжруулан, аж ахуйн тооцоон дээр ашигтай ажиллуулах бодлого, зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

6.6.8. Мал үржүүлгийн техникчийг сургах, бэлтгэх ажлыг хэрэгцээ, захиалгын дагуу тогтмол зохион байгуулан, мэргэжилтний хэрэгцээ, залгамж халааг бэлтгэх, тэдний ур чадварыг дээшлүүлэх;

6.6.9. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд зохиомол хээлтүүлэг, биотехнологийн ололтыг ашиглан малын ашиг шим, чанарыг дээшлүүлэх боломжийн талаарх сургалт, сурталчилгааг тогтмол зохион байгуулах;

6.6.10. Малын үржүүлэг, биотехнологийн чиглэлээр зөвлөмж, аргачлалыг боловсруулж, хэрэглэгчдийг мэдээ мэдээллээр тогтмол хангах .

“Малын удмын сангийн үндэсний үндэсний цогцолбор”-ийн II ээлжийн техник, эдийн үндэслэлд тусгагдсан барилга, байгууламжийг барьж байгуулах асуудлыг холбогдох шатанд тавьж шийдвэрлүүлэх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

Долоо. Хавсралт буюу стратеги төлөвлөлтийн тайлан

7.1. Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг байгууллагын захирал тухайн жил бүр баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах ба тайланг хагас болон жилийн эцсээр дүгнэж байна.

7.2. Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх төсвийг эх дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ. Үүнд:

- улсын төсөв;
- өөрийн үндсэн үйл ажиллагаа, туслах үйл ажиллагааны орлого;
- олон улсын төсөл хөтөлбөр, хандивлагч байгууллагуудын дэмжлэг.

7.3. Улс орон нутгийн төсвийн төлөвлөлт, санхүүжилт холбогдох хууль, тогтоомжийн дагуу хийгдэх бөгөөд МУСҮТ-с хамтран ажиллах байгууллагуудтай хэрэгжүүлэхээр тохирсон буюу төлөвлөж буй төсөл, хөтөлбөр, бусад ажлын санхүүжилтийг жил бүрээр харилцан тохирч гэрээ, төлөвлөгөөний үндсэн дээр баталгаажуулж ажиллана.

7.4. Байгууллагын төсвийг төсвийн ерөнхийлөн захирагчтай байгууллагын захирлын байгуулсан жил бүрийг гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын баталсан төвийн хуваарийн дагуу мэргэжилтнүүдийн үйл ажиллагаатай уялдуулан хуваарилах замаар зарцуулна;

7.5. Байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой, хөтөлбөр, төсөл болон төсвөөс олгогдсон хөрөнгийн зарцуулалтын тайланг тухай бүр гаргаж тайлагнана;

7.6. Байгууллагын үйл ажиллагааны төвшинд тавих хяналтыг төвийн захирал, байгууллагын төсвийн зарцуулалтын хяналтыг салбарын яамны санхүү, хөрөнгө оруулалтын нэгж тус тус хэрэгжүүлнэ;

7.7. Удирдлагын төвшинд шийдвэр гаргахад тухайн албаны дарга, мэргэжилтэн тухайн асуудлыг сайтар судалж, тооцсоны үндсэн дээр холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн, урьдчилан танилцуулж, зөвлөгөө авах замаар эцэслэн шийдвэрлүүлнэ;

7.8. Салбарын яам, Сайдаас өгсөн үүрэгт ажлуудыг шууд болон ажлын хэсэг байгуулах, багаар ажиллах хэлбэрээр хэрэгжүүлнэ.

7.9. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийн тооцооллыг Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нийцүүлж, шинэчилнэ.

Хүнс, хөдөө аж ахуй,
хөнгөн үйлдвэрийн Сайдын
2020 оны 4 дүгээр сарын 22-ны
өдрийн 17.1 хууль дугаар тушаалын
2 дугаар хавсралт

МАЛЫН УДМЫН САНГИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮТЭЦ

Малын генетик нөөцийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт "малын үндэсний генийн санг хамгаалах, сайжруулах чиг үүрэг бүхий төрийн үйлчилгээний байгууллага нь малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн төрийн төв байгууллагын харьяанд байна" заасан.

Дээрх нэр бүхий хууль тогтоомжид заасан эрх, чиг үүрэг, байгууллагын дүрэм, стратеги төлөвлөгөөнд нийцүүлж, Малын удмын сангийн үндэсний төвийн үйл ажиллагааны бүтцийг дор дурьдснаар тодорхойлж байна.

Нэг. Байгууллагын үүрэг хариуцлагын ерөнхий хуваарь:

1.1. Малын удмын сангийн үндэсний төв нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд малын үндэсний генийн санг хамгаалах, сайжруулах үндсэн үүрэг хүлээж, монгол малын генийг доройтох, мөхөх, устахаас сэргийлэх, хамгаалах, малын үржүүлгийн бүтээгдэхүүний генийн санг бүрдүүлэх, баяжуулах, хадгалах, дотоодод ашиглах үр, хөврөлийг үйлдвэрлэх, үржүүлгийн бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхойлох, малын үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээнд биотехнологийн ололтыг нэвтрүүлэх, нутагшуулах, дэлгэрүүлэх, малын зохиомол хээлтүүлгийн үйлчилгээ, явуулах цөм сүрэг бүрдүүлэх, бүс нутгийн үржлийн сайжруулагч хээлтэгч, хээлтүүлэгчийг хангах, мал үржүүлгийн техникч нарыг сургаж бэлтгэх, цөм сүргийн болон гойд ашиг шимт мал болон донор, тээгч малыг байршуулж ашиглах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

1.2. Малын удмын сангийн үндэсний төв нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд сайд болон яамны холбогдох газар, хэлтэс, байгууллагуудыг мэдээллээр хангаж, холбогдох орон нутгийн нэгжийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, тэдгээрийн харилцан уялдааг зохицуулах, хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Хоёр. Байгууллагын удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр:

Малын удмын сангийн үндэсний төвийн үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгч нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, дэд сайд сайд болон яамны холбогдох газар, хэлтэс, аймаг, нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, сум, дүүргийн хөдөө аж ахуйн тасаг, цөм сүргийн үржлийн аж ахуйн нэгж, хувийн хэвшлийн мал, үржүүлэг, технологийн нэгж, тэдгээрт ажиллаж буй мал аж ахуйн мэргэжилтнүүд, мал үржүүлгийн техникчид, мал бүхий аж ахуйн нэгж, иргэд, малчид, фермерүүд байна.

Төвийн үндсэн үйл ажиллагаа нь дээр дурдсан хэрэглэгчид, нэн ялангуяа, үндсэн үйлчлүүлэгч, хэрэглэгчийн эрэлт, хэрэгцээг хангахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад чиглэнэ.

Байгууллагын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн үндсэн үүрэг, чиг үүргийг стратегийн төлөвлөгөөний хүрээнд төрийн үйлчилгээний албан хаагчдын ажлын байр (албан тушаал)-ны тодорхойлолт, байгууллагын стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх жил бүрийн төлөвлөгөө, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээнд нарийвчлан тусгаж, хэрэгжилтийг зохион байгуулна гэж тооцоолов.

3. Бүтцийн ерөнхий загварыг боловсруулахад баримталсан зарчим

Байгууллагын үйл ажиллагааны бүтцийн ерөнхий загвар, зохион байгуулалтын бүтцийн нэгжийг тодорхойлон гаргахдаа дор дурдсан зарчмыг баримтлав:

3.1. Байгууллагын стратегийн зорилтыг бүтцэд тусгасан байх зарчим (тухайн байгууллагын үйл ажиллагааны бүтцийн тогтолцоо, зохион байгуулалтын бүтэц нь түүний үйл ажиллагааны стратегийн зорилттой уялдсан байх);

3.2. Эрх мэдлийн зааг ялгаа нь тодорхой үүрэг хүлээхүйц байх зарчим (бүтцийн нэгжүүд, тэдгээрийн удирдах албан тушаалын төвшин, нэр нь аль нэгж ямар асуудал эрхэлдэг, аль албан тушаал ямар эрх мэдэлтэй болохыг тодорхой мэдэж болохуйц байх, тэдгээрийн ажлын уялдаа, ажиллах чадвар нь итгэл хүлээхүйц байхын зэрэгцээ сайдын эрхлэх асуудлын хүрээний яам, агентлагийн зорилт, чиг үүрэгтэй давхардахгүй байх);

3.3. Үзэгдэхүйц төрийн үйлчилгээний баримжаатай байх зарчим (байгууллагын нэр, бүтцээс тухайн байгууллагын үйл ажиллагааны дүр төрх харагдахуйц байх, тухайлбал байгууллагын бүтэц, бүтцийн нэгжийн нэр нь түүний үйл ажиллагааны стратегийг тусгасан байх);

3.4. Бүтцийн хувьд энгийн байх зарчим (Захирлаас хамгийн доод нэгжээ хүртэл гурваас дээшгүй шат дамжлагатай байх);

3.5. Тэнцвэрийг хангах, хяналтын хүрээг тэлэх зарчим (байгууллагын үйл ажиллагааны стратеги, бүтэц хоёрын зөв зохистой тэнцвэрийг хангах замаар аль болох хялбар удирдах, хянах боломжтой байх, үйл ажиллагааны стратегийн зорилтыг аль болох оновчтой бүлэглэх замаар бүтцийн ерөнхий тогтолцоог тогтоосон байх, энэ нь удирдлагын чиг үүрэг, хүн хүчний болон бусад нөөцийг зөв хуваарилан хэрэглэгчийнхээ хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ үзүүлэх боломж бүрдүүлсэн байх);

3.6. Улс төржихгүй байх зарчим (тухайн байгууллагын төрийн үйлчилгээний албан хаагч нь эрхэлсэн сайд, Засгийн газар, бусад үйлчлүүлэгч буюу хэрэглэгчид төвийг сахисан, өндөр мэргэшлийн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүй байх);

3.7. Хангалттай чадавх, бодитой үйл ажиллагааны зарчим (үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар, зохион байгуулалтын бүтэц нь чадавхаа бүрэн илрүүлэхэд чиглэсэн, хэрэгжихүйц бөгөөд ажиллах чадвартай байх).

4. Үйл ажиллагааны бүтцийн ерөнхий загвар:

Дээр дурдсан зарчим болон байгууллагын үйл ажиллагааны стратегийн загварыг үндэслэн тус Малын удмын сангийн үндэсний төвийн үйл ажиллагааны бүтцийн ерөнхий загварыг дараах байдлаар тодорхойлж байна.

Малын удмын сангийн үндэсний төвийн үйл ажиллагааны бүтцийн ерөнхий загвар



5. Зохион байгуулалтын бүтцийн нэгж, тэдгээрийн үндсэн үүрэг, чиг үүрэг

Малын удмын сангийн үндэсний төвийн үйл ажиллагааны стратегийн болон бүтцийн ерөнхий тогтолцооны загвараас тус байгууллагын зохион байгуулалтын бүтцийн нэгж, тэдгээрийн үндсэн үүрэг, чиг үүргийг дараах байдлаар тодорхойлж байна:

5.1. Захиргаа, санхүүгийн асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг:

Энэ нэгж нь байгууллагын стратеги төлөвлөгөөний зорилтын хүрээнд төрийн захиргааны удирдлагаар хангах, байгууллагын санхүү, нягтлан бодох, бүртгэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлж, ил тод байдлыг хангах, тайлагнах, аппаратын дотоод зохицуулалт, үйлчилгээг эрхлэх, салбарын хүний нөөцийн бодлогыг төлөвлөх,

хэрэгжүүлэх, хууль эрх зүйн туслалцаа, зөвлөмж, ажиллах нөхцөл, нийгмийн баталгаагаар албан хаагчдын хангах, хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн биелэлтийн тайланг гаргах, олон нийттэй харилцах, чиг үүрэг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь байгууллагын үйл ажлыг оновчтой төлөвлөн зохион байгуулах, тайлагнах, сайдын эрхлэх асуудлын хүрээний холбогдох асуудлаар нэгдсэн удирдлагаар хангах, хүний нөөцийг чадавхжуулах, ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, авилга, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, төрийн болон байгууллагын нууцын асуудлыг эрхлэх, иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх, албан хаагчдын ажлаа тайлагнах, үүргээ биелүүлэх хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх, дээд байгууллагын тогтоол, шийдвэрийн биелэлт гаргах, олон нийттэй харилцах, байгууллагын үйл ажиллагааг сурталчлахад чиглэгдэнэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь МҮСҮТ-ийн захирал, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, дэд сайд, харьяа газар, хэлтсийн удирдлага, байгуулалтын бүтцийн нэгжүүд, албан хаагчид, иргэд байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь салбарын байгууллага, аж ахуйн нэгж, бусад хэрэглэгч байна. Үйлчилгээ үзүүлэхэд оролцох гол түнш нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, салбарын сургалт, эрдэм шинжилгээний байгууллага, мэргэжлийн төрийн болон төрийн бус байгууллага байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Сангийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон бусад яамд, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар байна.

5.2.Үйлдвэрлэл, технологийн асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг:

Энэ нэгж нь байгууллагын стратеги төлөвлөгөөний зорилтын хүрээнд малын үндэсний генийн санг уугуул болон тусгай орчинд хамгаалах, хадгалах, генийн сан бүрдүүлэх, гойд ашиг шимт цэвэр үүлдрийн донор мал болон тээгч малыг байршуулж үр, хөврөл үр, бусад үржүүлгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ашиглах, малын үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээнд биотехнологийн ололтын нэвтрүүлэх, нутагшуулах, дэлгэрүүлэх, зохиомол хээлтүүлгийн үйлчилгээний цар хүрээг тэлэх, үржлийн малд удам зүйн болон үржлийн үнэт чанарын үнэлгээ, молекул генетикийн шинжилгээ хийх, тодорхойлолт гаргах, мал үржүүлгийн техникч, мал ангилагч-шинжээч мэргэжилтэн бэлтгэх, давтан сургах, гэрээт мал үржүүлгийн техникч нарыг үржлийн бүтээгдэхүүн, багаж, тоног төхөөрөмж, шингэн азотоор хангах, хэрэглэгчийг малын үржлийн ажил, үйлчилгээтэй холбоотой мэдээллээр хангах замаар мал аж ахуйн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх, хэрэгжилтийг зохицуулах, зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн зарим чиг үүргийн хүрээнд Биотехнологи, генетикийн лаборатори, Малын үр, хөврөл үйлдвэрлэлийн лаборатори, цэвэр үүлдрийн болон донор малын болон бусад үйлдвэрлэлийн байгууламж хамаарна.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь төр, хувийн хэвшлийн эзэмшилд байгаа цэвэр үүлдрийн гойд ашиг шимт үржлийн мал болон үндэсний хэмжээнд үржүүлж байгаа үүлдэр, үүлдрийн хэсэг, омог хэвшлийн мал, тоо толгой нь цөөрч байгаа мал, амьтнаас үр, үржүүлгийн бүтээгдэхүүн авч генийн санд хадгалах замаар генийн санг хамгаалах, өсгөн арвижуулах, дотоодод ашиглах болон гапаапап гаргах үржүүлгийн бүтээгдэхүүнд гарал, үүслийн тодорхойлолт олгох, тэдгээрийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэн бодлого, төлөвлөгөөтэйгөөр үржилд ашиглах, мал үржлийн чиглэлийн сургалт, эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран орчин үеийн үржлийн биотехнологийн ололтыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, нутагшуулах, түгээн дэлгэрүүлэх, малын зохиомол хээлтүүлгийн ажил үйлчилгээг өргөжүүлэн иргэд, аж ахуйн нэгжүүдэд үйлчлэх, малын үржлийн чиглэлийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн ашигтай мэдээ, мэдээлэл, арга зүйн зөвлөгөө, зөвлөмжөөр хэрэглэгчдийг хангахад чиглэгдэнэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь мал бүхий иргэд, малчид, аж ахуйн нэгж, байгууллага байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь нутгийн захиргааны байгууллага, салбарын төрийн бус байгууллага, мэргэжлийн болон эрдэм шинжилгээ судалгаа, үйлдвэрлэлийн байгууллага, холбоо, хувийн хэвшлийн мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээний нэгж, мал үржүүлгийн техникч мэргэжилтнүүд, гадаад орон, олон улсын төсөл, хөтөлбөрийн байгууллагууд байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Сангийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон бусад яамд, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар байна.

5.3. Малын генийн санг хамгаалах, сайжруулах асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг:

Энэ нэгж нь байгууллагын стратеги төлөвлөгөөний зорилтын хүрээнд үндэсний генийн санг бүрдүүлэх, хадгалах, хамгаалах, аюулгүй байдлыг хангах, төр, хувийн хэвшилд байгаа баталгаажсан цөм сүргийн малыг уугуул орчинд нь хадгалж, хамгаалж, өсгөн үржүүлж, малын үржлийн стратегийн дагуу бүс нутгийн хэрэгцээг хангах, малын чанар, үүлдэрлэг байдал, ашиг шимийг сайжруулах, генийн санг шингэн азотаар хангах, үржүүлгийн бүтээгдэхүүний болон ашиг шимийн бүртгэл, мэдээллийн ажлыг хариуцах, зохицуулах зохион байгуула, үр дүнд хяналт тавих, тайлагнах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ. Энэ нэгжийн чиг үүргийн хүрээнд генийн сан, азот цех, 11 аймгийн Цөм сүргийн үржлийн төв, судалгаа, шинжилгээ, сургалтын чиг үүрэг бүхий ажилтнууд ажиллана.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллага, мэргэжлийн холбоод, ашиг шимийн зөвлөлүүд, мал бүхий этгээд, малчид, аж ахуйн нэгж, эрчимжсэн аж ахуй эрхлэгчид байх ба шууд бус хэрэглэгч нь мэргэжлийн төрийн бус байгууллага, мал бүхий аж ахуйн нэгж, хоршоод, гадаад орон, олон улсын төсөл, хөтөлбөрийн байгууллага болон бусад хэрэглэгч байна.

Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Сангийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон бусад яамд, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар байна.

5.4. Зохион байгуулалтын бүтцийн албан тушаалын нэр, орон тоо, албан тушаалын зэрэглэл

Д.Д	Бүтцийн нэгжийн нэр	Албан тушаалын нэр	Орон тоо	Албан тушаалын зэрэглэл
1	Захиргаа, санхүүгийн алба	Захирал	1	ТҮ-12
2		Захиргаа, санхүүгийн албаны дарга	1	ТҮ-11
3		Ерөнхий нягтлан бодогч	1	ТҮ-8
4		Төлөвлөлт хариуцсан эдийн засагч	1	ТҮ-7
5		Хүний нөөц, бичиг хэргийн мэргэжилтэн	1	ТҮ-7
6		Хуульч, дотоод, хяналт хариуцсан мэргэжилтэн	1	ТҮ-7
7		Архивын эрхлэгч		ТҮ-5
8		Нярав	1	ТҮ-4
9		Жолооч	1	ТҮ-3
10		Цахилгаанчин, слесарь	1	ТҮ-3
11		Үйлчлэгч	1	ТҮ-1
12		Жижүүр, сахиул	1	ТҮ-1
13		Үйлдвэрлэл, технологийн алба	Албаны дарга	1
14	Үр үйлдвэрлэлийн лабораторийн эрхлэгч шинжлэгч эмч		1	ТҮ-8
15	Молекул-генетикийн лабораторийн эрхлэгч, шинжлэн судлаач		1	ТҮ-8
16	Цогцолборын донор, тээгч малын эрүүл мэндийн асуудал хариуцсан малын эмч		1	ТҮ-7
17	Цогцолборын барилга байгууламж, малын арчилгаа, маллагаа, тэжээллэгийн асуудал хариуцсан мэргэжилтэн		1	ТҮ-7
18	Зохиомол хээлтүүлэг, хөврөл үр шилжүүлэн суулгах үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн		1	ТҮ-7
19	Биотехнологийн сургалт, малын ялган тэмдэглэлт хариуцсан мэргэжилтэн		1	ТҮ-7
20	Донор болон тээгч мал маллагч		1	ТҮ-3
21	Генийн санг хамгаалах, сайжруулах алба	Албаны дарга	1	ТҮ-11
22		Малын үндэсний генийн сангийн эрхлэгч бөгөөд малын үржүүлгийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн ашиглалт, хамгаалалт хариуцсан мэргэжилтэн	1	ТҮ-8
23		Шингэн азотын цехийн үйлдвэрлэл, түгээлт, борлуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн	1	ТҮ-8

24	Баянхонгор аймаг дахь цөм сүргийн нэгжийн менежер	1	ТҮ-7
25	Булган аймаг дахь цөм сүргийн нэгжийн менежер	1	ТҮ-7
26	Говь-Алтай аймаг дахь цөм сүргийн нэгжийн менежер	1	ТҮ-7
27	Дундговь аймаг дахь цөм сүргийн нэгжийн менежер	1	ТҮ-7
28	Дорнод аймаг дахь цөм сүргийн нэгжийн менежер	1	ТҮ-7
29	Завхан аймаг дахь цөм сүргийн нэгжийн менежер	1	ТҮ-7
30	Увс аймаг дахь цөм сүргийн нэгжийн менежер	1	ТҮ-7
31	Өмнөговь аймаг дахь цөм сүргийн нэгжийн менежер	1	ТҮ-7
32	Сүхбаатар аймаг дахь цөм сүргийн нэгжийн менежер	1	ТҮ-7
33	Хэнтий аймаг дахь цөм сүргийн нэгжийн менежер	1	ТҮ-7
34	Хөвсгөл аймаг дахь цөм сүргийн нэгжийн менежер	1	ТҮ-7

Байгууллагын стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг, албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтод стратегийн зорилт, үйл ажиллагааг тусгах замаар зохицуулалт, гүйцэтгэлийг хийж, биелэлтийг хангана.